

АГУУЛГА

1. Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	2
2. Алсын хараа үнэт зүйл	4
3. Удирдах зөвлөл	5
4. Хөгжлийн Шийдэл ТББ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд	6
5. Хөгжлийн Шийдэл ТББ-ын хамт олон	7
6. Хөгжлийн Шийдэл ТББ-ын салбарууд	8
7. Үйл ажиллагааны үр дүн	12
8. BEST хөтөлбөр	13
9. “Орон нутгийн хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих” хөтөлбөр төсөл	29
10. Залуу малчид, залуучуудын нийгэмд ээлтэй бизнес эрхлэх чадавхыг нэгэмдүүлэх төсөл	37
11. Завхан аймгийн малчдын нийгэм хамгааллыг өргөжүүлж, цочролд бэлэн байх чадавхыг нэмэгдүүлэх нь төсөл	43
12. “Орон нутгийн хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих” хөтөлбөр төсөл	39
13. “ҮБМ Залуусыг Бизнесийг Дэмжих Санаачлага” хөтөлбөр төсөл	47
14. Хамтрагч байгууллагууд	59



ГҮЙЦЭТГЭЛ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт харилцагчид, түншүүд, удирдах зөвлөлийн гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Сүүлийн 2 жилийн хугацаанд “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр нийгэм, эдийн засаг, иргэдийн амьдралын хэв маягт олон өөрчлөлтүүд гарсан төдийгүй бидний хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд ч томоохон сорилтуудтай тулгарсан. Хөгжлийн Шийдэл ТББ-ын хувьд өнгөрсөн хугацаанд Монголын жижиг, дунд бизнесүүд цар тахлын амаргүй цаг хугацааг даван туулахад туслахыг хамгийн гол зорилт болгон, эдгээр бизнесүүдийг засаглалын бодлогоо шинэчлэх, сорилтыг боломж, давуу тал болгох, бизнесийн оновчтой модел, шийдлүүдийг гаргахад онцгойлон анхаарч ажилласны үр дүнд энэ онд багагүй амжилттай ажиллалаа.

2021 онд бид Улаанбаатар хот болон 12 аймагт байрлаж буй салбаруудаараа дамжуулан 6038 харилцагч нарт хүрч үйлчлэн, 43,476,645,698 төгрөгийн зээлийг зуучилж, 654 ажлын байрыг шинээр бий болгоход зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн оны сүүлээр бид Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн (USAID)-ийн санхүүжилттэй “Бизнесийн Тогтвортой Хөгжлийн Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх” “(BEST) хөтөлбөр”-ийн

үйл ажиллагаа өргөжүүлж, дөрвөн аймагт шинэ салбарууд нээсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд бичил санхүүжилтийн хөтөлбөрийг орон нутгийн 8 аймагт амжилттай хэрэгжүүлж 410.3 сая төгрөгийн бичил санхүүжилтийг 43 байгууллагад олголоо.

НҮБ-ийн Хүн амын сантай хамтран хэрэгжүүлсэн орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлийн төсөл маань амжилттай хэрэгжиж дууссан бол Оюу Толгой ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Орон Нутгийн Хөдөө Аж Ахуйн Бизнесийг Дэмжих” хөтөлбөр хэрэгжээд 3 жил болсон байна. Хөтөлбөрийн зорилго нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээрээ бие даасан, өрсөлдөх чадвар бүхий бизнес, аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх замаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Хөтөлбөрийн хүрээнд Ханбогд суманд баригдах Махны үйлдвэрийн төслийг сумын засаг захиргаа, малчид, “Оюу толгой” ХХК-аас төлөөллөөс бүрдсэн гурван талт зөвлөлөөр батлуулан барилгын ажил 2022 онд эхэлж байгааг дуулгахад таатай байна.

Хөгжлийн Шийдэл төрийн бус байгууллага нь Олон Улсын Чанарын Удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандарт, Байгаль орчны менежментийн ISO 14001:2015 стандарт болон ХАБЭА менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартуудын үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ажилласнаар харилцагч нарт үзүүлж буй үйлчилгээ, зохион байгуулж буй үйл ажиллагаа улам чанаржаад зогсохгүй хамтран төсөл хэрэгжүүлж буй санхүүжүүлэгч байгууллагуудын итгэлийг улам бэхжүүлж өгч байна.

Мөн цар тахлын тархалт дэгдсэн хүнд үед манай байгууллага ажилтнуудын эрүүл ахуй аюулгүй байдлыг хангахын тулд гэр, оффисын хосолсон ажлын горимд шилжин ажилласан. Хэдий цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч зайнаас ажиллах шаардлага гарсан ч харилцагч нартаа чиглэсэн чадавхжуулах үйл ажиллагааг онлайн болон танхимын горимуудыг хослуулах замаар амжилттайгаар тасралтгүй үзүүлсэн.

Бид үйл ажиллагаагаа үр дүнтэй, тогтвортойгоор явуулахад та бүгдийн дэмжлэг, оролцоо маш чухал бөгөөд бөгөөд бидний хамтын ажиллагаа цаашид улам бэхжиж, Монгол улсын хөгжилд оруулж буй бидний хувь нэмэр өсөн нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,
Гүйцэтгэх захирал: Б.ГАНГИС

ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛС

АЛСЫН ХАРАА

- Хөгжлийн Шийдэл нь бизнесийн хөгжлийг дэмжих мэргэжлийн цогц үйлчилгээг үзүүлэгч Шинэлэг, Үр дүнтэй, Шилдэг байгууллага байна.
-

ЭРХЭМ ЗОРИЛГО

- Өрх гэрийн амьдралын чанарыг сайжруулна
 - Өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхыг бий болгоно
 - Байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ
-

ҮНЭТ ЗҮЙЛС

- Хөгжлийн Шийдэл нь алсын хараатай, ашгийн бус, бие даасан Монголын төрийн бус байгууллага юм.
 - Хөгжлийн Шийдэл нь харилцагч нэг бүрийн хэрэгцээнд тохирсон үнэ цэнэтэй, үр дүнд чиглэсэн бизнес хөгжлийн урт хугацааны цогц шийдлийг өргөн хүрээгээр үзүүлдэг.
 - Манай байгууллагын ажилтан бүр үр дүнтэй хамтын ажиллагааг эрхэмлэдэг бөгөөд дэлхийд танигдсан бизнесийн хөгжлийн арга, туршлагаар Монгол Улсын бичил болон, жижиг, дунд бизнесийн чадавхыг хөгжүүлэх ур чадвартай.
-

УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хөгжлийн Шийдэл ТББ-ын Удирдах Зөвлөл нь хууль эрх зүй, боловсрол, банк санхүү болон уул уурхайн салбарын төлөөллүүд бүхий хараат бус 5 гишүүдээс бүрддэг. Удирдах Зөвлөл нь жилд дөрвөн удаагийн ээлжит хурлыг зохион байгуулж, стратегийн болон цаг үеийн зохих шийдвэрүүдийг гаргах үүрэг бүхий удирдах дээд байгууллага юм.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



ТУЗ-н дарга:

1. Лувсандоржийн ОЮУН Ph.D /МУИС-ийн БС-ийн Санхүүгийн Хөтөлбөрийн багш доктор Профессор/

ТУЗ-н гишүүд:

2. Жигжидсүрэнгийн ГАНТӨМӨР /ХААН Банкны Бизнесийн зээлийн эрсдэлийн газрын Төслийн зээлийн Ахлах Менежер/
3. Жуковын БААТАРБОЛД /ХАС Банкны Салбарын Удирдлагын хэлтсийн Захирал/
4. Зоригийн ТУЯА /New Urbanism ХХК-н Захирал/
5. Жамбалдоржийн ЭРДЭНЭЧИМЭГ

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ-ЫН ҮЙЛЧИЛГЭЭ


- Бизнес хөгжил сургалтын үйлчилгээ
- Бизнесийн зөвлөх үйлчилгээ
- Байгууллагын сургалтын үйлчилгээ
- Бизнес холболтын үйлчилгээ
- Олон нийтэд зориулсан мэдээллийн үйлчилгээ
- Санхүүгийн үйлчилгээ
- Бизнесийн бүлэг, хоршоо хөгжүүлэх үйлчилгээ
- ТББ-г чадавхжуулах үйлчилгээ
- Судалгаа хийх
- Гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр
- Менторинг

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ-ЫН ХАМТ ОЛОН

Хөгжлийн Шийдэл ТББ нийт 70 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд үүнээс 34 нь Улаанбаатар хотод ажиллаж бол үлдсэн 36 ажилтан нь орон нутгийн 13 салбарт ажиллаж байна.



ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ САЛБАНУУД







ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД



01

ЖДБ ДЭМЖИХ ЧИГЛЭЛД



“БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ САЙЖРУУЛАХ, ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ (BEST)” ХӨТӨЛБӨР

Жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн сайн засаглал, хариуцлага, ил тод байдлыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэн өсгөхөд чиглэнэ.

02

ХАА-Н БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛД



“ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ” ТӨСӨЛ

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээрээ бие даасан, өрсөлдөх чадвар бүхий бизнес, аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх замаар Ханбогд сумын эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.



03 04 05

ГАРААНЫ БИЗНЕС ДЭМЖИХ ЧИГЛЭЛД



ЗАЛУУ МАЛЧИД, ЗАЛУУЧУУДЫН
НИЙГЭМД ЭЭЛТЭЙ БИЗНЕС
ЭРХЛЭХ ЧАДАВХЫГ
НЭГЭМДҮҮЛЭХ ТӨСӨЛ

Уг төсөл нь тухайн орон
нутагт тохирсон залуучуудын
энтрепренершип хөгжлийн
эко-систем бий болгох
замаар Өмнөговь аймаг,
Ханбогд сумын залуу
малчид, залуучуудын
нийгэмд ээлтэй бизнес
эрхлэх чадварыг
нэмэгдүүлэх зорилготой юм.



ЗАВХАН АЙМГИЙН МАЛЧДЫН
НИЙГЭМ ХАМГААЛЛЫГ ӨРГӨЖҮҮЛЖ,
ЦОЧРОЛД БЭЛЭН БАЙХ ЧАДАВХЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ

Энэхүү төсөл нь малчдын бизнес санал
санаачилгыг өргөжүүлж, тэдний орлогыг
нэмэгдүүлэх, хоршооны үйл ажиллагааг
дэмжих замаар тэдний нийгмийн
даатгал, эрүүл мэндийн даатгалд
хамрагдалтыг нэмэгдүүлж, нийгмийн
халамжийн тогтолцоог ашиглан малчин
өрхийн байгалийн гамшиг, цочролд
бэлэн байдлыг нэмэгдүүлж, цочролын
дараах нийгмийн хамгааллын үйлчилгээг
сайжруулах зорилготой.



ҮБМ ЗАЛУУСЫГ
БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ
САНААЧЛАГА ТӨСӨЛ

18-35 насны зорилтот
бүлгийн залууст зориулан
энтрепренершипийн цогц
хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

2021 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

2008 ОНООС ХОЙШХИ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

47

Шинэ бизнес

1169

Өргөжин сайжирсан бизнес

654

Шинээр бий болсон ажлын байр

9666

Сургалтад суусан хүмүүсийн тоо

437

Ментор

4,846,860,750 MNT

Борлуулалтын орлогын өсөлт

43,476,645,698 MNT

Амжилттай зээлийн зуучлал

875

Амжилттай зуучилсан банкны зээлийн тоо

130

Бизнесийн бүлэг хоршоо, төрийн бус байгууллага

1479

16-35 насны бизнес эрхлэгчид

2690

16-35 насны сургалтад оролцогчид

4472

Шинэ бизнес

9386

Өргөжин сайжирсан бизнес

20888

Шинээр бий болсон ажлын байр

32323

Сургалтад суусан хүмүүсийн тоо

765

Ментор

13,822,046,550 MNT

Борлуулалтын орлогын өсөлт

180,577,705,448 MNT

Амжилттай зээлийн зуучлал

10191

Амжилттай зуучилсан банкны зээлийн тоо

723

Бизнесийн бүлэг хоршоо, төрийн бус байгууллага

15425

16-35 насны бизнес эрхлэгчид

17921

16-35 насны сургалтад оролцогчид



USAID
АМЕРИКИЙН АРД ТҮМНЭЭС



**ХӨГЖЛИЙН
ШИЙДЭЛ**

шинэлэг · үр дүнтэй · шилдэг



**"БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ
САЙЖРУУЛАХ, ИЛ ТОД БАЙДЛЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ" ХӨТӨЛБӨР**



» “БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ САЙЖРУУЛАХ, ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨР

Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID) – ийн санхүүжилтээр “Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх (BEST)” хөтөлбөрийг Улаанбаатар хот, Завхан, Орхон, Ховд, Дархан-Уул, Дорноговь, Өвөрхангай, Дорнод, Сэлэнгэ, Баянхонгор, Өмнөговь, Хэнтий болон Хөвсгөл аймагт 2019 оны 12 дугаар сарын 02-ноос 2024 оны 12 дугаар сарын 01 хүртэл таван жилийн хугацаатай хэрэгжүүлж байна.





USAID
АМЕРИКИЙН АРА ТҮМ

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн сайн засаглал, хариуцлага, ил тод байдлыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэн өсгөхөд чиглэнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ:

1

ЖДБ-ийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх;

2

ЖДБ-ийн засаглалыг сайжруулах;

3

ЖДБ-ийн үйл ажиллагааг дэмждэг төрийн болон төрийн бус байгууллагуудын ил тод байдлыг хангах, хяналтын тогтолцоог бэхжүүлэх;

4

Бизнесийн хөгжлийн стратегийг тодорхойлоход чиглэсэн судалгааг хийх;

5

Цаашид тогтвортой хөгжих боломжтой, санхүүжилт авах чадамжгүй төрийн бус байгууллага, гарааны болон жижиг бизнес эрхлэгчдэд бичил санхүүжилт олгох зэрэг болно.

ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- ЖДБ-үүдэд санхүү, төлөвлөлт, менежмент, компанийн засаглалын чиглэлээр сургалт, урт хугацааны болон богино хугацааны зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- Зээлийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх, зээл санхүүжилтэд холбох;
- ЖДБ-ийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн төрийн байгууллагуудын албан хаагчдыг авилгаас ангид ил тод байлгах чиглэлээр чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулах;
- ЖДБ-ийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, бизнес холбоодыг чадавхжуулах сургалт, уулзалт хэлэлцүүлэг форумыг зохион байгуулах;
- Судалгаа хийх.
- ЖДБ болон ТББ-уудад бичил буцалтгүй санхүүжилт олгох.

“ 2021 он Ковид-19 цар тахлаас шалгаалан бүх нийтийн хөл хорио, тогтвортой үйл ажиллагааг хязгаарлах, хилийн хорио зэрэг нөхцөл байдлаас үүдэн эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч тухайлбал ЖДБ-үүдийн хувьд энэ нь хүндээр туссан жил болж өнгөрсөн. Хорио цээрийн бэрхшээлийг үл харгалзан BEST хөтөлбөр нь ЖДБ эрхлэгчдэд виртуал хэлбэрээр сургалт, зөвлөх үйлчилгээг тасралтгүй үзүүлсээр ирсэн. BEST хөтөлбөр нь хөтөлбөрийн үр шим хүртэгч ЖДБ-үүдээ энэхүү хүндрэлийг даван туулах, эрсдлийг бууруулахад амжилттай тусалж ажилласан жил байлаа. Мөн BEST хөтөлбөр нь ЖДБ нарын чадварыг нэмэгдүүлэх, засаглалыг сайжруулах зориулан 8 төрлийн гарын авлага гаргаж ажиллахын зэрэгцээ “Даван туулагч бүсгүйчүүд”, “Орон нутгийн кластерын хөгжил”, “Маргаашийн ЖДҮ” зэрэг сэдвүүдээр форумуудыг зохион байгуулсан.

”

BEST ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

2021 ОНЫ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

ХӨТӨЛБӨР ЭХЭЛСНЭЭС ХОЙШХИ ҮР ДҮН

290

Бизнесийг өргөжин
сайжрахад нь тусалсан.

2,029,457,363₮

борлуулалтын орлогыг
өсөхөд нь тусалсан

280

ажлын байр нэмэгдүүлсэн

30,881,449,487₮

Зуучилсан зээлийн дүн

43

Буцалтгүй мөнгөн дэмжлэг
олгосон бизнес

587

Бизнесийг өргөжин
сайжрахад нь тусалсан.

4,807,080,750₮

борлуулалтын орлогыг
өсөхөд нь тусалсан

596

ажлын байр нэмэгдүүлсэн

43,440,925,698

Зуучилсан зээлийн дүн



55

Буцалтгүй мөнгөн дэмжлэг
олгосон бизнес

» ЗОРИЛТ 1: ЖДБ-ИЙН САНХҮҮЖИЛТ АВАХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Уг зорилтын хүрээнд зээл авах хүсэлтэй ч зээл авахад хүндрэлтэй ЖДБ эрхлэгчдийг чадавхжуулах бизнес хөгжлийн сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээс гадна зээлийн зуучлалын үйлчилгээ, мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа. 2021 оны хувьд ЖДБ-үүдэд бизнес загвараа шинэчилж, хямралыг даван туулах арга замаа тодорхойлоход чиглэсэн сургалт, зөвлөх үйлчилгээг түлхүү үзүүлэн нь ЖДБ-н хувьд бизнесийн тогтвортой байдал, цаашлаад зээл санхүүжилт авах боломжид эерэг нөлөөтэй байлаа.

2021 ОНЫ ЗОРИЛТ 1-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



160

Зохион байгуулсан сургалт

3205

Сургалтанд оролцогчдын тоо

30,881,449,487₮

Амжилттай зуучилсан
зээлийн дүн



108

Зохион
байгуулагдсан
уулзалт



2230

Уулзалтанд
оролцогчдын тоо

» ЗОРИЛТ 2: ЖДБ-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ


Зорилтын хүрээнд зорилтот харилцагчид болох ЖДБ-ийн хувьцаа эзэмшигчид, удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирлуудад ЖДБ-үүдийн онцлогт тохирсон сургалт, зөвлөгөө, уулзалтуудыг зохион байгуулсан. Мөн ОУСК-аас гаргасан Жижиг Дунд Аж Ахуйн Нэгжийн Засаглалын гарын авлагыг албан ёсны эрхтэйгээр орчуулан харилцагчиддаа түгээлээ. Ковид 19-ын халдварын тархалтын улмаас Монгол Улсын Засгийн засгийн газраас авсан арга хэмжээнүүд нь албан бизнесийг дэмжихэд чиглэж байсан нь ЖДБ-ийн эзэд засаглалаа сайжруулахад анхаарах боллоо.

2021 ОНЫ ЗОРИЛТ 2-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



31

Урт хугацааны
зөвлөгөө авсан
ЖДҮ



288


Засаглалаа сайжруулсан
бизнесийн тоо

115

ЖДБ засаглал
сайжруулах
сургалт


1936

Сургалтын
оролцогчдын
тоо



251

Богино
хугацааны
зөвлөгөө
авсан ЖДҮ



128 ЖДБ засаглал
сайжруулах уулзалт

1776

Уулзатын
оролцогчдын
тоо




» **ЗОРИЛТ 3: ЖДБ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖДЭГ ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ**

2021 ОНЫ ЗОРИЛТ 3-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



5

Төрийн бодлогод санал оруулсан



26

Зохион байгуулагдсан авилгалын эсрэг сургалт



331

Сургалтанд хамрагдсан ТББ



563





Сургалтанд хамрагдсан ТАХ



BEST хөтөлбөр нь 2021 оны хувьд Цар тахлын үеийн эдийн засгийн бодлого тодорхойлох үйл ажиллагаануудад Төрийн болон төрийн бус байгууллагуудтай нягт хамтарч ажилласан. Тухайлбал Улсын онцгой комиссын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлд харилцагч ЖДБ эрхлэгчдэд тулгараад байгаа үндсэн бэрхшээлүүд, нэн шаардлагатай байгаа төрийн дэмжлэгүүдийн тодорхойлж, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын саналыг нэгтгэн хүргүүлсэн. Мөн Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих төвд “Цар тахлын үед нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг боловсруулахад санал өгч ажилласан.



» ЗОРИЛТ 4: БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛОХОД ЧИГЛЭСЭН СУДАЛГААГ ХИЙХ

2021 ОНЫ ЗОРИЛТ 4-ЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД



» **ЗОРИЛТ 5:** ЦААШИД ТОГТВОРТОЙ ХӨГЖИХ БОЛОМЖТОЙ, САНХҮҮЖИЛТ АВАХ
ЧАДАМЖГҮЙ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ГАРААНЫ БОЛОН ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД
БИЧИЛ САНХҮҮЖИЛТ ОЛГОХ

2021 ОНЫ ЗОРИЛТ 5-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



2021 онд BEST хөтөлбөр нь тэтгэлэг олгосон харилцагч нартаа чадавхжуулах, засаглалаа сайжруулах, байгаль орчны менежментийн чиглэлээр сургалт, зөвлөх үйлчилгээнүүдийг үзүүлж, зээлийн зуучлалд хамруулж байна. 2021 онд нийт 410 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

ФОРУМЫН МОДЕРАТОРООР:

- URBAN брэндийн үүсгэн байгуулагч, Захирал Д.Тунгалаг

ИЛТГЭГЧИД:

- Траст Трейд ХХК-ийн Захирал Р.Сансармаа,
- Жүр Үр ХХК-ийн Захирал Б.Мөнхзул,
- Ивээл Брэндийн үүсгэн байгуулагч, Захирал З.Рэгзэдмаа,
- Lhamouг брэндийн үүсгэн байгуулагч, Захирал Д.Хулан



"ДАВАН ТУУЛАГЧ БҮСГҮЙЧҮҮД" ЦАХИМ ФОРУМ

Монгол улсын эдийн засаг, нийгэмд үзүүлж буй эмэгтэй бизнес эрхлэгчдийн үүргийг таниулах, харилцан бизнесийн туршлага солилцох, Ковид-19 цар тахлын үед бизнесээ хэрхэн амжилттай удирдах тухай оролцогч бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд урам зориг өгөх зорилготой "ДАВАН ТУУЛАГЧ БҮСГҮЙЧҮҮД" форумыг цахим хэлбэрээр ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд бизнесийн салбарт туршлагатай, амжилттай явж буй 5 дотоодын үйлдвэрлэгч байгууллагын эмэгтэй захирлууд уригдан BEST хөтөлбөрийн харилцагч Улаанбаатар хот болон орон нутгийн 100 бизнес эрхлэгч бүсгүйчүүдэд цар тахлын хүнд үеийг хэрхэн даван туулсан, цаашид юуг төлөвлөж, хаашаа зорьж байгаа талаар өөрсдийн

бизнесийн туршлагаас ярьж, хэрхэн ажиллаж байгаа талаар нээлттэй сэтгэгдлээ хуваалцсан хэлэлцүүлэг болж өнгөрлөө. Мөн уг форумд шийдвэр гаргах түвшний эмэгтэй төрийн албан хаагч, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ийн төлөөллүүд оролцсон юм.



“

ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан энэхүү форумын үеэр онлайн худалдааны Zochil.mn платформ ажиллаж эмэгтэй бизнес эрхлэгчдийг цахимаар борлуулалтаа өсгөх таатай боломжууд бүрдсэн.

”


МАРГААШИЙН ЖДҮ ЦАХИМ ФОРУМ

BEST хөтөлбөр нь 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр ЖДБ нарыг Ковид 19-өөс үүдэлтэй “ШИНЭ ХЭВИЙН” нөхцөлд дасан зохицох замаар амжилттайгаар бизнесийн шилжилт хийхэд дэмжлэг болох урам зориг өгөх зорилгоор “МАРГААШИЙН ЖДҮ” форумыг зохион байгууллаа.

Форумын хүрээнд ЖДБ нарт цар тахлын дараах шинэ орчин буюу ирээдүйд гарах бизнесийн орчны өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл өгөх, хүний нөөцийн шинэ хандлагыг таниулах, цахим шилжилт хийх болон ирээдүйд тогтвортой үйл ажиллагаа эрхлэхэд анхаарах шаардлагатай хүчин зүйлс, өөрчлөлтөд хэрхэн амжилттай дасан зохицох зэрэг сэдвүүдээр амжилттай яваа бизнесийн зөвлөхүүд болон энтрепренерүүдийн сонирхолтой судалгаа, мэдээлэл, шинэ арга барилыг хуваалцаж сонирхолтой хэлэлцүүлгийг өрнүүлсэн нь цаг үеэ олсон арга хэмжээ байсныг оролцогч ЖДБ-үүд маань онцолж байсан.

Форумд АНУ-аас Монгол Улсад байгаа Элчин Сайд Майкл Клечески оролцон мэндчилгээ хүргэсэн ба хөтөлбөр хэрэгжиж буй аймгууд болон УБ хотын ЖДБ эрхлэгчдийн төлөөлөл, арилжааны 10 банк, 8 аймгийн Засаг дарга нар, төрийн албан хаагчдаас бүрдсэн 500 гаруй оролцогчид оролцсон. Цахим форумын хамрах хүрээг илүү өргөн, үр дүнтэй байлгах, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд цахим хэлбэрээр YouTube, Facebook зэрэг сошиал сувгуудаар шууд дамжуулсан. Мөн BEST хөтөлбөрийн Facebook цахим хуудас болон You Tube сувагт нөхөн үзэх боломжтойгоор байршуулсны үр дүнд 15 мянга гаруй бизнесийн төлөөлөл үзсэн.





ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ КЛАСТЕРИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГААР ДЭМЖИХ НЬ ВИРТУАЛ ФОРУМ 2021

Цар тахлын дараах бизнесийн шинэ хэв маягийн орчинд орон нутгийн жижиг бизнесүүдийн хамтран хөгжих, кластерийг дэмжих чиглэлээр олон улсын болон дотоодын боломжууд, сайн туршлагыг хуваалцах зорилготой “Цар тахлын дараах шинэ хэвийн байдал: Орон нутгийн хөгжлийг кластерийн хамтын ажиллагаагаар дэмжих нь” виртуал форумыг 2021 оны 4-р сарын 28-ны өдөр амжилттай зохион байгуулсан.

Энэхүү үйл ажиллагаанд АНУ-ын Элчин сайд Майкл Клечески, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлагийн төлөөллүүд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар, 6 аймгийн Засаг дарга болон тэдгээрийн ажлын албаныхан, 8 аймгийн жижиг дунд бизнесийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, жижиг дунд бизнесүүдийн төлөөлөл зэрэг 225 оролцогчид оролцлоо.

Форумд “Орон нутгийн жижиг дунд бизнесүүд хэрхэн хамтран нэгдэх, кластер бий болгон хөгжих боломж, арга замын талаар олон улсын болон дотоодын судалгаа, мөн төрийн дэмжлэг, бодлого”, “Жижиг дунд бизнесүүд нэгдэх боломж ба сайн туршлага” гэсэн 2 үндсэн сэдвээр эрдэмтэн судлаачид, төрийн байгууллагын мэргэжилтэн, томоохон туршлага бүхий бизнесийн захирал, ХААН банкны төлөөлөл илтгэл тавилаа.

Орон нутгийнхны хувьд цаашид орон нутагт тус бүрийн онцлогт нь суурилсан хөгжлийн стратегиа тодорхойлж, бизнесүүд кластер хэлбэрээр нэгдэн, илүү том зах зээл рүү аж ахуйн нэгжүүдийн ханган нийлүүлэгч болох цаашилбал экспортын чиг баримжаатай хөгжих зайлшгүй хэрэгцээ бидэнд байгаа ба төрийн зүгээс бодлого хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэл нь кластерийг дэмжихэд чиглэж байгааг энэхүү форумаар онцолсон юм.

АМЖИЛТЫН ТҮҮХ

“ИХ ӨСӨЛТ” ХХК-ийн захирал,
“АРИГУН” тансаг зэрэглэлийн лааны брэндийг
үүсгэн байгуулагч **ХОРЛООГИЙН ИХБАЯР**.



Экологийн цэвэр бүтээгдэхүүнүүд ашиглан эрүүл мэндэд ямар ч сөрөг нөлөөгүй, байгальд ээлтэй лааг эх орондоо үйлдвэрлэж байгаа түүний бизнесийн санаа 2012 оноос эхтэй. Таван жилийн бодол, судалгааны үр дүнд анхны бүтээгдэхүүнээ 2017 оны наймдугаар сарын 25-ны өдөр хэрэглэгчдэд хүргэжээ.

Бизнесээ хэрхэн эхлүүлсэн талаар тэр бээр хэлэхдээ: “Англи улсад боловсрол эзэмшээд 2012 онд эх орондоо ирж, төрийн албан хаагч болсон. Гэтэл ороод удаагүй байтал сонгууль болж, халаа сэлгээ эхэлж жирэмсний амралттай байсан намайг хүртэл халсан. Ингээд л цаашид юу хийх, хэрхэх талаараа бодохоос өөр аргагүйд хүрсэн. Англид байхдаа шар буурцгийн тосоор хийсэн лаа их хэрэглэдэг байсан. Европод шар буурцгийн тосоор хийсэн лаа талхтай л адил хэрэглээтэй. Монголд ирээд хайтал ер олддоггүй. Хийдэг хүн байхгүй, импортоор ч орж ирдэггүй байсан. Ингээд л судалгааны ажилдаа ханцуй шамлан орсон.

Сургалтаас олж авсан мэдлэгээ тэр бээр шууд л бүтээж хэрэгжүүлэх ажилдаа орсон байна. Сав баглаа боодол, бүтээгдэхүүний төрөл дээр ажиллахын хажуугаар лааг хэрхэн гэрийн чимэглэлтэй хоршуулж, экологийн цэвэр байдлаар мөн тансгаар урлах тал дээр ажиллаж эхэлжээ. Лаа гэдэг гэрт асаагаад орхидог эд биш тул аюулгүй байдал, эрүүл мэндийн талд сайтар анхаарах ёстойг тэрбээр анхнаасаа тооцсон байна. Тиймээс

Интернэтээс лааны талаар анхан шатны мэдээллийг авч, улмаар Англи улсад болдог цахим сургалтад сууж орц найрлага, үнэр, тортоггүй, биед хоргүй байлгахын тулд яах ёстой гээд анхан шатны мэдлэгийг олж авсан.” гэсэн юм.



л эдийн чанар, аюулгүй байдал зэрэгт өөрийн хэмжээнд судалгаа хийж, өдөр бүр сайжруулна гэсэн зорилттой ажилладгаа онцолж байлаа.

Манай улс тансаг хэрэглээний ихэнхи лааны хэрэгцээг импортоор хангадаг бөгөөд энэ тоо жилээс жилд өссөөр байна. Импортын лааны 95 хувь нь парафин буюу бензинээс гаргаж авсан тосоор хийдэг тул үнэ хямд. Хүмүүс лаа үнэртэй, гэрэл гаргаж байх ёстой гэж боддог ч химийн гаралтай бүтээгдэхүүнээр хийсэн лаа хэтдээ хор уршиг ихтэй байдаг аж.

Тиймээс дэлхийн зах зээлд эрэлт ихтэй парафингүй, ургамлын, байгалийн гаралтай лааг Аригун брэнд үйлдвэрлэж байна. “Ашигтай ажиллая гэвэл би парафинаар лаа хийж болно. Гэхдээ Монгол Улсад анх удаа шар

буурцгийн тосоор, Монголчууддаа зориулж байгаа учраас чанартай түүхий эдээр хийхийг зорьсон. “Богино хугацанд ашиг олохоос илүү урт хугацаандаа үргэлжлэх бизнесийг хийж байна” хэмээн өөрийн итгэл үнэмшил, баримталж буй зарчмаа тэрбээр хуваалцсан”. Анх бүтээгдэхүүнээ борлуулах газар хайж явсан тэрбээр одоо 35 орчим дэлгүүрээр борлуулалт хийхээс гадна Говьсүмбэр, Эрдэнэтийн хэрэглэгчдэд ч хүрч чадсан байна. Тэр ч бүү хэл арлын Японы стандартыг давж, 2018 онд нэг тонн лааг экспортолсон байна. Тус улсын лааны холбооны сургалтад сууж, албан ёсны гишүүн ч болоод амжжээ.



“Бид хэдийгээр жижиг үйлдвэр боловч, сууриа маш сайн тавиад чанар, стандартыг хангаж ажиллаж байна. 126 сая хүн амтай энэ том зах зээлд тодорхой хэмжээнд тогтмол экспортлодог болчих юм бол дараагийн улс уруу экспортолно гэж төлөвлөж байна.” Түүний хувьд бусад жижиг, дунд бизнес эрхлэгчийн адилаар ачаалал ихтэй, голдуу борлуулалт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт дээр анхаарал хандуулдаад байж. Гэтэл бизнес нь өсөн дэвшиж томрохын хэрээр бизнесээ үр дүнтэй удирдан жолоодох, дотоод зохион байгуулалт, бизнес төлөвлөлт зэрэг компанийн урт хугацааны хөгжилд нөлөөлөх олон асуудлыг орхигдуулдаг байжээ. Иймд энэ чиглэлээр бусдаас туслалцаа хүсэхээр шийдсэн ба АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Хөгжлийн Шийдэл ТББ-ийн хамтран хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрт хандан компанийн засаглалын сургалт, зөвлөгөөнд хамрагдан олон жил толгойндоо бодож явдаг байсан алсын хараа, зорилгоо бодитоор цаасанд буулгаж хэрэгжүүлж эхэлснээр өмнө нь тэр бүр анхаарал хандуулдаггүй байсан санхүү, хүний нөөц, төлөвлөлт, хяналт зэрэг олон асуудлууд илүү уялдаа холбоотой болж, компани нь цаашдаа компаниа нэгдмэл удирдлагаар ханган, томорч хөгжих боломж нь нээгдсэн.

Ярилцлагын эцэст тэрбээр бизнест анх удаа хөл тавих гэж байгаа хүмүүст хандан “Нэгдүгээрт тууштай байж итгэл үнэмшилдээ үнэнч байх хэрэгтэй. Судалгааг маш сайн хийх хэрэгтэй. Бизнес сургалт, зөвлөгөө, хэлэлцүүлэгт оролцож өөрийн анзаараагүй өнцгүүдийг бусдаас суралцан олж мэдэн өөрийгөө тасралтгүй хөгжүүлж байх нь чухал.” хэмээсэн.



**"ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН
БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ" ТӨСӨЛ**

“ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ” ТӨСӨЛ

Орон Нутгийн Хөдөө Аж Ахуйн Бизнесийг Дэмжих хөтөлбөрийг Оюу Толгой ХХК ны санхүүжилтээр Ханбогд Хөгжлийн Шийдэл ТББ, Өмнөговь аймгийн Ханбогд суманд хэрэгжүүлж байна.

АЛСЫН ХАРАА:

ТОГТВОРТОЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ БИЙ БОЛГОХ, ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ МӨН ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

- 1 МАЛЧДЫН ТОГТВОРТОЙ ХҮНС НИЙЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ
- 2 ХҮНСНИЙ ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН СУДАЛГААНЫ БАТАЛГАА БОЛОН ЗАСАГЛАЛ
- 3 МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ БОЛОН БОЛОВСРУУЛАЛТ
- 4 МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН МАРКЕТИНГ, НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ

2021 ОНЫ ЗӨВЛӨГӨӨ, СУРГАЛТ, УУЛЗАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ:



160

оролцогчтой 44
удаагийн сургалт
зохион байгуулсан.

1006

хандалттай 2
видео танилцуулга
хийсэн.



710

оролцогчтой 307
удаагийн уулзалт
хийсэн.



80

малчдыг хамруулсан
5-н ЖДБ, хоршоодыг
дэмжиж ажилласан.

88

Бизнес төсөл, судалгааны
дүгнэлт, танилцуулга,
зөвлөх үйлчилгээний
тайлан, зөвлөмж
боловсруулсан.

1. МАЛЧДЫН ТОГТВОРТОЙ ХҮНС НИЙЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ

ГОВЬ ХАН УРАН ХХК

Говь Хан Уран ХХК-д тендерт оролцож худалдан авалтын гэрээ байгуулахтай холбоотой материалуудыг боловсруулах, компанийн хувьцаа эзэмшигчдэд засаглалын ойлголт өгөх, гүйцэтгэх захирал солигдохтой холбоотой бичиг баримт бүрдүүлэлт, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах, хүний нөөцийн бодлогын бичиг баримт боловсруулах, түүхий эдийг татахтай холбоотой агуулах, татвар, тайлагнал, баримт бүрдүүлэлт, маркетингийн брэнд бүк боловсруулах зэрэг чиглэлээр зөвлөгөө өглөө.

ЭНЕРГИЙН УНДАРГА ХОРШОО

2020 төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээ хийж 2021 оны ажлын төлөвлөгөөг боловсруулахтай холбоотой зөвлөгөө малчин аппликэйшнийг нэвтрүүлэх, Оюу Толгой ХХК-ны ханган нийлүүлэлтийн системд бүртгүүлэх, шинээр 12 баримт бичгийг боловсруулж, хоршооны даргаар баталгаажуулан гишүүдэд хүргүүлсэн. Өмнөговь аймгийн хэмжээнд зохион байгуулсан хоршооны тухай сургалтад хоршооны даргыг хамруулсан.

ҮНЭЭГИЙН ГОВЬ ХОРШОО

Үнээгийн говь хоршооны 2020 оны гүйцэтгэлийн үнэлгээ хийж 2021 оны төлөвлөгөөтэй боловсруулах, малчин аппликэйшн ашиглах зөвлөмж өгсөн. Хоршооны гишүүд тус тусынхариулж буйАнгус үхрүүдээ хоршооны нэр дээр тооллогод хамруулсан нь засаглал сайжирч, нийт гишүүд хоршооны зохион байгуулалтад итгэж эхэлж буйг харуулсан үйлдэл болсон.

ГАВИЛУУД ШИЛМЭЛ СҮРЭГ ХОРШОО

Гавилууд Шилмэл сүрэг хоршоонд дотоод журам, хуц ухна хариулах үйлчилгээний гэрээ боловсруулж өгсөн. 2020 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээ, 2021 оны төлөвлөгөөтэй холбоотой зөвлөгөө өгсөн.Гишүүд тус тусын хариулж буй хонинуудыг хоршооны нэр дээр тооллогод хамруулсан.Арьс шир боловсруулах чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг судалж, 2 гишүүнээ энэ чиглэлийн сургалтад хамруулахаар болсон, бизнес төсөл бичсэн.

2. ХҮНСНИЙ ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН СУДАЛГААНЫ БАТАЛГАА БОЛОН ЗАСАГЛАЛ

10:40



МАЛЧИН АПП


Малчид өөрийн хоршооны хуралд цахимаар оролцож, шийдвэр гаргах, санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллээ авах боломжтой, цахим шийдлийг ХБ-ын малчдад 2021 онд нэвтрүүлсэн.

“Оюу толгой” ХХК нь Ханбогд сумын ЗДТГ болон Ханбогд сумын малчдын төлөөлөлтэй хийсэн гомдол барагдуулах гэрээний дагуу Ханбогд суманд Мал нядалгааны үйлдвэр, Малчны зах зэрэг төслүүдийн бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэж буй.

Энэхүү төслүүдийн хөрөнгийг өмчлөх, удирдлага, зохион байгуулалтыг хариуцах аж ахуйн нэгжийг Ханбогд сумын баг бүрийн анхан шатны хоршоод хамтарч байгуулсан дундын хоршоо байх нь зүйтэй гэж багуудын хурал дээрх санал асуулгаар шийдвэрлэсэн. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй хоршоодын хувьд гишүүддээ мэдээлэл хуваалцдаггүй, гишүүдийн идэвх оролцоо хангалтгүй, нээлттэй бус зэрэг асуудал байнга тулгарч байна.

Түүнчлэн хоршооны хувьд хэн нэгэн этгээдийн хувийн ашиг сонирхол давамгайлж төслийн өгөөжийг хувьдаа завших эрсдэлтэй байдаг. “Оюу толгой” ХХК-ны зүгээс хоршоодын ил тод байдлыг нэмэгдүүлэх, гишүүдийн оролцоо, хяналтыг сайжруулах зорилгоор хоршооны засаглалын “МАЛЧИН” аппликэйшнийг хөгжүүлж цаашдын тогтвортой үйл ажиллагааг нь Хөгжлийн Шийдэл ТББ-д хариуцахаар болсон.

Тус аппликэйшнийг ашигласнаар малчид өөрийн анхан шатны хоршоо болон дундын хоршооны үйл ажиллагаа, санхүүтэй холбоотой бүхий л мэдээллийг нээлттэй хүлээн авч болно.



“МАЛЧИН” АППЛИКЕЙШНЫ ДАВУУ ТАЛУУД

- Малчид хоршооныхоо санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг цаг тухайд нь авснаар хяналт тавих боломжтой болно.
- Бүх гишүүний хурал, хяналтын зөвлөлийн хурал, тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлуудад цахимаар оролцож, хараат бусаар саналаа өгч болно.
- Хоршооны дотоод асуудлаар нийт гишүүн малчдаас санал авах, хэлэлцүүлэх боломжтой.
- Цаг завгүй, сумаас хол байдгаас шалтгаалан оролцож чадахгүй гишүүдийн тоо багасна. Цахим талбарт малчид хоршооны бүх гишүүний хуралд хэлэлцүүлэх ёстой асуудалтай танилцаж, шийдвэрт санал өгч болно.
- Малчид цаг уур, түүхий эдийн үнэ ханш, мал эмнэлгийн үйлчилгээ, төрийн зарим үйлчилгээтэй холбоотой мэдээлэл авна.
- Хүссэн үедээ шаардлагатай зараа оруулах, устгах боломжтой.
- Хоршоонд бүртгэлтэй бүх гишүүдийн профайлтай танилцаж, холбоо тогтоох боломжтой

МЭДЭЭЛЛИЙН ТАЛБАР:

- | | |
|-----------------------|----------------------------------|
| • Мэдээ мэдээлэл | • Зар мэдээ |
| • Цахим хурал | • Цаг уур |
| • Цахим санал асуулга | • Хууль, эрх зүй |
| • Судалгаа | • Хоршооны дүрэм журам |
| • Хэлэлцүүлэг | • Санхүү, үйл ажиллагааны тайлан |

ХОЛБООСУУД:

- Youth Business Mongolia (facebook хуудас)
- Залуу бизнесийг дэмжих групп Youth Business Mongolia (facebook групп)
- <https://ybmongolia.org/> (website)

3. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ БОЛОН БОЛОВСРУУЛАЛТ

Ханбогд сумын 4 багт анхан шатны хоршоо байгуулах, 4 багууд дээр шинээр байгуулагдах анхан шатны хоршоодыг нэгтгэсэн дундын хоршоо байгуулах бэлтгэлийг хангасан.

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн малчдын төлөөлөлд сумын дөрвөн баг дээр анхан шатны хоршоо, сумын хэмжээний дундын хоршоо байгуулахтай холбоотой сургалтуудыг зохион байгууллаа.

Малчдын хоршоо байгуулах ажилтай холбоотой анхан шатны хоршоодын дүрмийн төслийг боловсруулж, Гурван талт зөвлөлийн хоршоо байгуулах ажлын хэсэгтэй хамтран дөрвөн багийн нийт 370 хувь тарааж, нийт малчдад хүргүүлсэн. Малчдын хоршоо байгуулах чиглэлээр видео танилцуулга бэлтгэж Гурван талт зөвлөлийн пэйж дээр байршууллаа.

Хоршоо байгуулахтай холбоотой бичиг баримт, дүрэм журмуудыг боловсруулж малчдын төлөөлөлд хүлээлгэн өгсөн.

МАЛ НЯДАЛГААНЫ ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХЭД БЭЛЭН БОЛСОН

Мал нядалгааны зам төслийн барилгын зураг төсөлтэй холбоотойгоор газрын байршлыг үйлдвэрийн стандарт шаардлагад нийцүүлэн тогтоож, зураг төсөл захиалахад бэлэн боллоо.

Махны үйлдвэрийн технологи, тоног төхөөрөмж, барилгын онцлогтой холбоотой мэдээлэл цуглуулах зорилгоор махны үйлдвэрүүдээр очиж үзэж, барилгын материалын худалдааны төвүүд, барилгын компаниуд, бохирын шийдэл борлуулагч компаниудын төлөөлөл, махны технологийн инженер, махны салбарын зөвлөх инженерүүдтэй уулзаж мэдээлэл цуглууллаа.

Ханбогд сумын ЗДТГ-тай хамтран барилгын зураг төслийг баталгаажуулахтай холбоотой аймгийн Онцгой байдлын газрын дүгнэлт, Мэргэжлийн хяналтын газрын

дүгнэлт, Барилга-хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвийн магадлагаа, шугам сүлжээний байгууллагуудын баталгаажуулалтыг хийлгэж барилгын тендер зарлахад бэлэн болголоо. Мал нядалгааны зам төслийн Байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж Байгаль Орчин Аялал Жуулчлалын яамны ажлын хэсгээр батлуулсан. Байгаль орчны үнэлгээний дагуу мэргэжлийн байгууллагуудын саналаархатуу хог хаягдлыг ЗДТГ-тай гэрээ байгуулан зориулалтын хогийн цэгт хаях шингэн хог хаягдлыг Хан дизель ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан цэвэрлэх байгууламжид нийлүүлэхээр шийдвэрлэсэн.

4. МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН МАРКЕТИНГ, НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ

Малчны зах, түүхий эдийн захын газрын байршил тодорхой болж, уг газар дээр барих барилга байгууламж, дэд бүтцийн зураг төслийг боловсруулан мэргэжлийн байгууллагаар батлуулан барилгын ажлыг эхлүүлэхэд бэлэн боллоо.

LASS хөтөлбөрийг Ханбогд сумын ХАА г дэмжих хөтөлбөртэй уялдуулах, Оюу толгой ХХК-аас тус хөтөлбөр дээр хэрэгжүүлэхээр амласан төслүүдийн хоорондын уялдааг сайжруулах санал боловсрууллаа.

ТЭСО ХХК-нд малчдаас тэмээний сүү нийлүүлэхтэй холбоотой ажилд судалгаа, тээвэр логистикийн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Ханбогд сумын хонь, тэмээний ноосыг эдийн засгийн эргэлтэд оруулах төслийн урьдчилсан хэрэгжих боломжийн судалгаа хийсэн.

СУДАЛГААНЫ ХҮРЭЭ:

- Ноосны зах зээл, түүхий эдийн нөөц
- Нэмэгдсэн өртгийн тооцоолол, боловсруулах үе шат
- Усны хэрэглээ
- Шаардлагатай хөрөнгө оруулалтууд
- Байгаль орчны нөлөөлөл






**ЗАЛУУ МАЛЧИД, ЗАЛУУЧУУДЫН НИЙГЭМД
ЭЭЛТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭХ ЧАДАВХЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ**

ЗАЛУУ МАЛЧИД, ЗАЛУУЧУУДЫН НИЙГЭМД ЭЭЛТЭЙ **БИЗНЕС ЭРХЛЭХ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ:**

НҮБ-ын Хүн Амын Сан, Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сангийн хамтарсан санхүүжилтээр Өмнөговь аймагт хэрэгжиж буй “Өмнөговь аймгийн Эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөр 2018-2021”-ийн 5-р үр дүн буюу “Залуучууд, өсвөр насныхны оролцоог нэмэгдүүлэх” 5.3 “Залуучуудын гарааны бизнес, залуу малчдын хоршоодыг дэмжсэн байх” гэсэн зорилтын хүрээнд Хөгжлийн Шийдэл ТББ-аас RACE хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Өмнөговь аймаг, тэр дундаа Ханбогд сумын залуучуудын нийгэмд ээлтэй энтрепренершип мэдлэг болон сэтгэлгээг хөгжүүлэх, нийгэмд ээлтэй бизнес эрхлэх замаар амьдарлын түвшин болон тухайн орон нутагтаа эерэг өөрчлөлт бий болгоход чиглэн ажиллахаар Rural Acceleration Community Entrepreneurship (RACE) буюу “Орон Нутгийн Залуусын Энтрепренершип” дэд төслийг хэрэгжүүлэн 2021 оны 12 сард дууслаа.

RACE ТӨСӨЛ НЬ ТУХАЙН ОРОН НУТАГТ ТОХИРСОН ЗАЛУУЧУУДЫН ЭНТРЕПРЕНЕРШИП ХӨГЖЛИЙН ЭКО-СИСТЕМ БИЙ БОЛГОХ ЗАМААР ӨМНӨГОВЬ АЙМАГ, ХАНБОГД СУМЫН ЗАЛУУ МАЛЧИД, ЗАЛУУЧУУДЫН НИЙГЭМД ЭЭЛТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭХ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГОТой ЮМ.



Энэхүү төслөөр НҮБ-ын Хүн амын сан (UNFPA)-тай хамтран Өмнөговь аймгийн Ханбогд, Даланзадгад сумдын малчид, залуусын нийгэмд ээлтэй бизнес эрхлэх чадавхыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлээ. Орон нутгийн малчид, залуусын нийгэмд ээлтэй бизнес эрхлэх чадавхыг нэмэгдүүлэх төслийн хүрээнд гарааны бизнесийн сургалт, хурдасгуурын сургалт, гарааны бизнесийн сонгон шалгаруулалт зохион байгууллаа.

1211

иргэдийг сургалтанд
хамруулсан

80

бизнес төсөл
боловсруулахад
зөвлөгөө өгсөн

40

шинэ бизнесийг
шалгаруулан
санхүүжилт өгсөн

Энэхүү дэд төсөл нь НҮБ-ын хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ, Монгол улсын Засгийн газар, Өмнөговь аймаг, Австралийн Элчин сайдын яам болон Оюу Толгой ХХК-аас санхүүждэг Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сантай хамтран хэрэгжүүлж буй “Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөр” ийн хүрээнд хэрэгжсэн бөгөөд Өмнөговь аймаг болон Ханбогд суманд төвлөрөн хэрэгжсэн юм.

RACE төслийн хүрээнд орон нутгийн оролцогч талуудтай хамтран Ханбогд сумын залуу малчид болон залуучуудыг нийгэмд ээлтэй бизнес эрхлэх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн цуврал сургалт, уулзалт зохион байгуулах, санхүүжилт болон бизнес чадвар олгох замаар гарааны бизнес хөгжүүлэх, Ханбогд сумын Залуучуудын Хөгжлийн Төвийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэсэн үйл ажиллагааны загвар тодорхойлох зэрэг ажлуудыг хийж хэрэгжүүлээ.

Сургалтыг танхимын сургалтаас илүү залуусын оролцоог илүү дэмжих зорилгоор багаар нь ажиллуулан, туршлагажин суралцах байдлаар явуулсан. Сургалтын материалууд Youth Business International олон улсын байгууллагын бизнес хөгжүүлэлтийн материалаас бэлтгэсэн бөгөөд бизнес төсөл боловсруулах, эффе́ктэ́шн, загварлан сэтгэхүй аргачлалыг ашиглан заалаа.

СУРГАЛТАД ОРОЛЦОГЧДЫН ТОО:

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Ханбогд, Даланзадгадын сургалтуудыг заримыг нь онлайнаар, заримыг нь газар дээр нь хийсэн.

БАЙРШИЛ	ТОО
ХАНБОГД СУМ	212
ДАЛАНЗАДГАД	232
ДАЛАНЗАДГАД, ОНЛАЙН ФОРУМ	340

БОЛОВСРУУЛСАН БИЗНЕС ТӨСЛИЙН ТОО:

Орон нутгийн иргэдийн бизнес санааг гарааны бизнесийн сонгон шалгаруулалтад оролцуулахын тулд бизнес төсөл, танилцуулга боловсруулах ажил дээр Хөгжлийн Шийдэл ТББ-ын бизнесийн зөвлөхүүд ажилласан.

БАЙРШИЛ	ТӨСЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ	ГАРААНЫ БИЗНЕСИЙН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦСОН ТОО
ХАНБОГД СУМ	22	72
ДАЛАНЗАДГАД	29	62
НИЙТ	51	134



САНХҮҮЖИЛТ АВАХААР ШАЛГАРСАН ГАРААНЫ БИЗНЕСҮҮД, ТЭДГЭЭР ТӨСЛҮҮДЭД ОРОЛЦОГЧ ЗАЛУУС, МАЛЧДЫН ТОО:

БАЙРШИЛ	ШАЛГАРСАН БИЗНЕСИЙН ТОО	ТӨСЛИЙН ОРОЛЦОГЧДЫН ТОО
ХАНБОГД СУМ	8	32
ДАЛАНЗАДГАД	22	26
НИЙТ	30	58

Онлайнаар сургалт, үйл ажиллагаа явуулсан газруудад, манай үйл ажиллагааг сонирхсон, цаашид энэ чиглэлээр мэдээлэл, сургалт авах сонирхолтой иргэдийг олон нийтийн сүлжээний групп дээр нэгтгэж авсан.

БАЙРШИЛ	ТОО
ХАНБОГД СУМ	108
ДАЛАНЗАДГАД	434





JOINT SDG FUND



**“ЗАВХАН АЙМГИЙН МАЛЧДЫН НИЙГЭМ
ХАМГААЛЛЫГ ӨРГӨЖҮҮЛЖ, ЦОЧРОЛД БЭЛЭН
БАЙХ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ**

ЗАВХАН АЙМГИЙН МАЛЧДЫН НИЙГЭМ ХАМГААЛЛЫГ ӨРГӨЖҮҮЛЖ, **ЦОЧРОЛД БЭЛЭН БАЙХ** **ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ**

Joint SDG Fund-ийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүн амын сангаас “Малчдын нийгмийн хамгааллыг сайжруулж, цочролд бэлэн байх чадавхыг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд Завхан аймгийн Идэр, Отгон, Их-Уул, Дөрвөлжин, Тэс сумдын малчдын 14 бүлэг, хоршоонд гарааны бизнесийг хөгжүүлэх 138 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.



Сургалтыг танхимын сургалтаас илүү залуусын оролцоог илүү дэмжих зорилгоор багаар нь ажиллуулсан, туршлагажин суралцах байдлаар явуулсан. Сургалтын материалууд Youth Business International олон улсын байгууллагын бизнес хөгжүүлэлтийн материалаас бэлтгэсэн бөгөөд бизнес төсөл боловсруулах, эффектэшн, загварлан сэтгэхүй аргачлалыг ашиглан заалаа.



ТӨСЛИЙН ҮР ДҮН


Хөгжлийн Шийдэл ТББ-аас малчдад бизнес санаагаа хөгжүүлэх, бизнес төсөл бичих, төслөө хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн судалгаа, худалдан авалт хийхэд нь дэмжлэг үзүүлж ажиллалаа.

2021 ОНЫ ТӨСЛИЙН ҮР ДҮН




227

Сургалтанд
хамрагдсан
малчдын тоо



14

Санхүүжилт авахаар
шалгарсан гарааны
бизнесийн тоо



29

Боловсруулсан
бизнес
төслийн сонгон
шалгаруулалт




105

Санхүүжилт
авахаар оролцсон
төслүүдийн
оролцогчдын тоо



134

Гарааны бизнесийн
шалгаруулалтад оролцсон тоо







**ҮБМ ЗАЛУУСЫГ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ
САНААЧЛАГА ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ**



Англид төвтэй Youth Business International санаачлага 2013 оноос эхлэн Монгол улсад өөрийн үйл ажиллагаа явуулахаар болсон. Youth Business International санаачлага нь залуучуудын бизнес эрхлэлтийг дэмжих замаар тэднийг ажилтай, орлоготой иргэн болгож давхар ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд манай улсад үйл ажиллагаа явуулахаар болсон нь хүн амын дийлэнх хэсгийг залуучууд эзэлдэг орны хувьд том боломж болж байна. Youth Business International санаачлагын хувьд тухайн улсдаа бизнесийг дэмжих чиглэлээр амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа туршлага бүхий, шилдэг байгууллагатай хамтран ажилладаг бөгөөд Хөгжлийн Шийдэл ТББ – ыг энэхүү санаачлагыг Монгол дахь хэрэгжүүлэгчээр сонгосон. Монгол улс дахь үйл ажиллагаа YBM буюу Youth Business Mongolia нэртэйгээр хэрэгжиж байна.





ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЖ БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН САЙЖРУУЛАХ НЬ СУРГАЛТ, УУЛЗАЛТ

Орчин үеийн чухал хандлагуудын нэг болсон хүртээмжтэй байдлын ач холбогдлыг Хойд Америк болон Баруун Европ харьцангуй илүү сайн ойлгодог. Хүртээмжтэй байдлын дэмжсэнээр тухайн байгууллагын нэр хүнд ОУ-н стандартаар огцом нэмэгдэхээс гадна, ажилчдаа хадгалж үлдэх, ашгаа өсгөх, нэмэлт хөрөнгө оруулалт татах боломж нээгдэх зэрэг маш олон давуу талтай байдаг билээ. Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх явцыг хурдасгах, хөгжлийн сорилтуудыг даван хүртээмжтэй байдлын ойлголтыг нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой. Хүртээмжтэй байдлын ач холбогдлыг Youth Business International ОУ-н байгууллага таниулах хүрээнд гишүүн байгууллагууддаа тогтмол чанартай сургалтуудыг олгож хамруулдаг.

Ялгаварлан гадуурхалтын сөрөг нөлөөг таниулах, байгууллагын бүтээмж, ажилчдын энтрепренершип санаачилга болон уран сэтгэмжийг нэмэгдүүлэх аргуудаас хуваалцах, мэдлэг мэдээлэл түгээх, залуучуудын эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх, залуу бизнес эрхлэгчдэд ур чадвар олгох зорилготой YBI-с олгосон сургалтыг Монгол залуус болон нийгэмд зориулж өөрчлөн уялдуулж шинэчилсэн сургалтыг Залуу Бизнесийг Дэмжих Санаачлага тогтмол Улаанбаатар хотод болон орон нутгаар зохион байгуулдаг билээ. Ялгаварлан гадуурхалтын сөрөг нөлөөг ойлгож, мөн санамсаргүй байдлаар ялгаварлан гадуурхалт явагдаж бизнест сөрөг нөлөө үзүүлж болох талаар мэдлэг олгох нь энэ сургалтын гол зорилго юм. Хүртээмжтэй байдлыг дэмжсэнээр бизнест олон төрлийн давуу талууд үүсэж болох талаар оролцогчид мэдлэгтэй болдог.

YBI ГИШҮҮНЧЛЭЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

Youth Business International байгууллага нь гишүүнчлэлийг бүртгэх, сунгахдаа гишүүн байгууллагын үйл ажиллагаа, санхүү болон засаглалын асуудлыг хянан үнэлдэг. 2021 онд тус гишүүнчлэлийн баталгаажуулалтад гурав дахь удаагаа орж 2024 хүртэл гишүүнчлэл албан ёсоор сунгагдав.

MENTOR

2021 ОНЫ ҮНДЭСНИЙ ШИЛДЭГ
МЕНТОР Ц.ОЮУНЧУЛУУН

АМЖИЛТИЙН ТҮҮХ

Ц.Оюунчулуун ментор нь 2015 оноос хойш Youth Business Mongolia хөтөлбөрийн сайн дурын ментороор ажиллаж байна. Маркетинг болон санхүүгийн чиглэлээр жилд 10 гаруй ментиг чиглүүлэн ажилладаг. Энтрепренер залууст өөрийн мэдлэг, туршлагаа бусадтай харамгүй хуваалцахаас гадна нийгмийн өөрчлөлттэй хөл нийлүүлэн алхах сэтгэлийн хат, алсын хараа, өөрийгөө таних, бусдад илэрхийлэх тал дээр зөвлөн ажилладаг. Тэрээр хэлэхдээ “Менти нар маань нүдэн дээр минь өөрчлөгдөж, хөгжиж байгааг харахад үргэлж таатай байдаг” гэжээ. Тэрээр хэлэхдээ “Менторинг бол харилцан суралцах боломжийг бүрдүүлдэг, сайн дурын, буянтай үйл ажиллагаа. Менти нар урам зоригтой болж, зорилгоо томруулж байвал, нөгөө талаас бизнес дээр нь болон хувь хүнд гарсан эерэг өөрчлөлт, хөгжлийг өөрийн нүдээр харахад бахархах сэтгэл төрдөг.” Түүний менти нарын нэг нь Сүүн Гэр ХХК-н захирал Пагма



юм. Тэдний компаний нь “Өглөөний цайгаа заавал уу, өлөн элгээ зөв тайл” уриатай 3 төрлийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. 2018 онд хүүхдүүдээ хараад гэртээ сууж байх хугацаанд эмэгтэйчүүдийн бизнес сэтгэлгээний талаарх сургалт хөтөлбөрт хамрагдаж, анх Оюунчулуун ментортойгоо танилцаж байсан. Эмэгтэйчүүдийг нийгэмд чадавхжуулах, тэдний нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэх оролцоог нэмэгдүүлэх сургалтанд анх сууж байсан. Пагма хэлэхдээ “Оюунчулуун ментор тухайн үед өөрөө харагдах байдлаараа хүчирхэг, өөртөө итгэлтэй, хүнийг итгэн үнэмшүүлэх, урам зориг өгч, байгаа байдал нь маш их таалагдаж, өөрийн мэдэлгүй бидний ментор болох хүн байна гэсэн хүслийг төрүүлж байсан” хэмээжээ.

Гарааны бизнесийг хөгжүүлэх, өргөжүүлэхэд хөнгөлөлттэй зээл, урт хугацааны хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай. Санхүүгийн хүртээмж муу байгаагаас олон гарааны бизнес бүтэлгүйтдэг. ЖДҮ-ийг хөгжүүлэх санд жил бүр олон мянган аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт гаргадаг ч тэдний цөөн нь л амжилтад хүрдэг. Гэхдээ сайн менторын тусламжтайгаар дөрвөн шатны шалгаруулалтад тэнцэж, засгийн газраас хамгийн бага хүүтэй зээл авч чадсан.

Дэлхийн 30 гаруй оронд амжилттай цацагдсан Shark Tank бизнесийн реалити шоуны Монгол хувилбарын 3-р улирал нь 2021 оны 10-р сарын 24-ний өдрөөс эхлэн цацагдаж эхэлсэн. Бизнесээ амжилттай хэрэгжүүлсний үр дүнд бид Монголын шилдэг 4 бизнесийн магнатаас хөрөнгө оруулалтыг хүлээн авч чадсан. Энэхүү амжилтын хурдаараа тэдний компани Монголын хамгийн том сүлжээ дэлгүүрүүдийн нэг болох CU-ын ханган нийлүүлэгч болж, борлуулалтаа гурав дахин нэмэгдүүлж чаджээ. Үүнээс гадна эргэлтийн хөрөнгөө 2.5 дахин, үндсэн хөрөнгөө 4 дахин, ашгаа 40%-р, ажиллагсдын тоог 3-р нэмэгдүүлсэн байна.

Пагма хэлэхдээ “Энэ бүх амжилтанд хүргэсэн хүн бол манай Ментор Оюунчулуун юм. Манай зөвлөгч нь бидэнд шаардлагатай энергийг өгдөг хүчирхэгжүүлэгч юм. Түүний бидэнд өгч буй итгэл үнэмшил, бидний бизнесийг бий болгоход тусалсан нэн шаардлагатай оюуны хөрөнгө оруулалтад бид үргэлж талархаж явдаг” хэмээжээ.





ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтэй Залуучуудын Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Төслийн хүрээнд Дорнод болон Дундговь аймгуудад 30 менторуудыг бэлдэв. Тэд хувийн, иргэний нийгмийн болон төрийн байгууллагуудад ажилласан туршлагатай бөгөөд орон нутгийн залуучуудын гарааны бизнес, хөдөлмөр эрхлэлтэд өөрсдийн мэдлэг, туршлагаа хуваалцан зөвлөн чиглүүлэх үйлсэд зүтгэх юм. Мөн тус төсөлтэй хамтран Завхан, Дорноговь, Хэнтий, Дархан-Уул аймгийн 18–35 насны 20 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд 5 долоо хоногийн менторинг үйлчилгээг хүргэв.

МАЛЧДЫН АМЖИРГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ

Оюу Толгой ХХК-ийн дэмжлэгтэйгээр “Малчдын амжиргааг дээшлүүлэх” төслийн зорилтот бүлгийн малчин энтрепренерүүдийг дэмжин ажиллахаар Өмнөговь аймгийн Даланзадгад болон Ханбогд сумдаас 12 ментор бэлдэв.



ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР ТӨСӨЛ

Японы Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар” төслөөр 5 аймгийн 25 сумдын бизнесийн мэдлэг, туршлагатай 100 гаруй иргэдийг менторын сургалтад хамруулан өсвөрийн энтрепренерүүдийн шинэ санаа, санаачилгад зөвлөн чиглүүлэхэд холбов.

ГАРААНЫ БИЗНЕСИЙН АРГА ХЭМЖЭЭ

Гарааны бизнесийн арга хэмжээ нь тухайн орон нутгийн 15-35 насны бизнес эрхлэх сонирхолтой залууст гарааны бизнесийн сургалт болон зөвлөгөөг 2 өдрийн турш өглөө 09 цагаас 17 цаг хүртэл өгч 3дах өдөр сонгон шалгаруулалтын Pitch day арга хэмжээг зохион байгуулдаг. Хөтөлбөрийг зохион байгуулахдаа насанд хүрсэн хүмүүсийн онцлогт тохируулан оролцооны аргад суурилсан орчин үеийн сургалтын андрогоги арга, ментор зөвлөх үйлчилгээний техник ашигласан бөгөөд онолын мэдлэгийг олгохоос гадна жишээ, кейс ажиллуулах, тайлбарлан таниулах, өөрсдөөр нь яриулах, өөрсдийн санаан дээр нь зөвлөгөө өгөх ажиллуулах, дасгал хийлгэх сургалтын идэвхийг нэмэгдүүлэх үүднээс сэргээх тоглоом, сонирхолтой яриа өрнүүлэх зэрэг арга аргачлалуудыг ашигладаг. Мөн хөтөлбөрийн явцад зах зээлийн судалгаа хийж, оролцогчид загвар бүтээгдэхүүнтэй болох боломжтой байдаг. Хөтөлбөр дараах 3-н үе шаттай явагддаг.

2-Р ҮЕ ШАТ

1-Р ҮЕ ШАТ

Энэ үе шатанд оролцогчид бизнес санаагаа хөгжүүлэхийн тулд орон нутагт болон орон нутгийн иргэдэд, гадна дотны жуулчдад тулгараад байгаа асуудлыг тодорхойлж, тухайн асуудлуудыг шийдэх гарц, гаргалгааг өөрсдийн бизнестэй уялдуулан бизнес санаагаа хөгжүүлдэг.

Оролцогчид дараах мэдлэгүүдийг олж авдаг:

- Бизнес санааг зөв сонгох, санаагаа хөгжүүлэх аргачлал
- Мэдрэмжтэйгээр бизнесээ хийх нь арга
- Бизнес загварчлал буюу 1 хуудсанд багтаасан бизнес төлөвлөгөөний агуулга боловсруулах.

3-Р ҮЕ ШАГ

Сургалтын сүүлийн өдөр хөрөнгө оруулагчдад санаагаа танилцуулах танилцуулга презентаци бэлтгэхэд чиглүүлж зөвлөгөө өгсөн. Мөн бүтээгдэхүүний санаагаа сайжруулан загвар бүтээгдэхүүнээ гаргасан.

Баг бүр өөрсдийн бизнес санаанд оношилгоо хийж, хамгийн тохиромжтой бизнес санааг сонгох, өөрийн санааны бизнес загвараа боловсруулж, менторуудын тусламжтайгаар санаагаа хөгжүүлж, хамрагдсан сургалтын дагуу багаар ажиллан зах зээл, хэрэглэгч, өрсөлдөгчийн судалгаа хийдэг. Энэ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээг илрүүлэх чухал ажил юм. Энэ үеэр бизнес санааг хөгжүүлэх, бизнес загвар, бүтээгдэхүүн хөгжүүлэлт буюу дизайн тинкинг сургалт явагддаг.

- Бүтээгдэхүүний өртөг тооцоолол, үр дүнгийн тооцоолол хийх
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлт
- Төслийн танилцуулга бэлдэх

Эдгээр өдрүүдэд багуудын бизнесийн санааг зөвлөх менторууд бизнес төлөвлөгөөний дагуу хөгжүүлэхэд зөвлөгөө өгөн ажилласан.



2021 онд гарааны бизнесийн арга хэмжээ нь Говьсүмбэр, Сэлэнгэ, Архангай, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Орхон аймгууд болон Улаанбаатар хотын Сүхбаатар болон Налайх дүүргүүдэд тус тус зохион байгуулагдсан. Эрэгтэй-80, эмэгтэй-138, нийт 218 оролцогч хамрагдсан. Нийт оролцогчдоос 11 бизнес 110 сая төгрөгийн санхүүжилт авч чадсан



ОЛОН УЛСЫН ӨСВӨРИЙН ЭНТРЕПРЕНЕРҮҮДИЙН УРАЛДААН 2021

Японы Хүүхдийг Ивээх Сантай хамтран жил бүр зохион байгуулдаг тус арга хэмжээ нь цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цахим хэлбэрээр, үндэсний болон олон улсын гэсэн 2 тойргоор болов. 2016 оноос зөвхөн Улаанбаатар хотын дунд, ахлах болон мэргэжлийн сургуулиудын сурагчдын дунд англи хэлээр зарлагдан шалгаруулалт хийгддэг байсан бол 2021 онд цахим боломжийг ашиглан монгол хэлээр орон нутгийн сургуулийн сурагчдыг урьсан. Ингэснээр Баян-Өлгий, Өвөрхангай, Төв, Завхан аймгийн сурагчид маш идэвхтэй оролцов.

Олон улсын тэмцээнд өрсөлдөх тойрогт нийт 24 баг оролцож дараах 3 баг олон улсын тэмцээний эрхээ авсан.

- Bridge баг (Сант болон Орчлон сургуулийн сурагчдын хамтарсан баг)
- Monsamurai Technologies баг (1, 11, 76, 84, Орчлон, Шинэ Монгол Коосэн, Бритиш Скүүл сургуулийн сурагчдын хамтарсан баг)
- Focus баг (44-р сургуулийн сурагчид)

2021 оны 5 сарын 27-ны өдөр Global Youth Entrepreneurship Challenge олон улсын уралдаанд эдгээр багууд “Байгалийн болон хүний оролцоотойгоор сүйдэж буй хөрсийг дахин сэргээх бизнес санаа” гаргах чиглэлээр 23 улсын сурагчдын багуудтай өрсөлдөж эхний 12 байрт жагссан.

Үндэсний түвшний монгол хэл дээрх уралдаанд 23 баг оролцсоноос дараах 3 баг шилдгээр шалгарсан.

- Alternative баг (Томужин сургуулийн сурагчдын баг)
- BUD Power баг (44-р сургуулийн сурагчдын баг)
- Cognoscenti баг (Хобби сургуулийн сурагчдын баг)

2022 онд GYEC тэмцээнд оролцох багуудыг илүү олон аймаг, сургуулиудаас хамруулахаар уралдааны зохион байгуулагч баг ажиллаж байна.



ЗАЛУУ БИЗНЕС ЭРХЛЭГЧИДИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ САЙЖРУУЛЖ, ӨСӨЛТИЙГ ХУРДАСГАХ ХӨТӨЛБӨР (GPS FOR ENTREPRENEURS)


Залуу Бизнес Эрхлэгчидийн Гүйцэтгэлийг Сайжруулж, Өсөлтийг Хурдасгах хөтөлбөр нь Youth Business International олон улсын байгууллагын сургагч багш нарыг бэлтгэдэг хөтөлбөрүүдийг нэг юм. Бизнес эрхлэгчид хамрагдах долоон дэд сэдэв бүхий уг сургалтыг заах эрхийн сургалтанд сууж шалгалтаар баталгаажиж байж олж авдаг. 'Хөгжлийн Шийдэл' ТББ-н 3-н сургагч багш уг сургалтыг албан ёсны заах эрхтэйгээр зааж байна. Сургалтын долоон дэд сэдвээс бизнес эрхлэгчдэд хэрэгцээтэй олон төрлийн чадваруудаас суралцаж авдаг. ХОНХ гэх товчлолтой сургалт нь Хувирамтгай, Ойлгомжгүй, Нарийн Төвөгтэй, Хоёрдмол бизнесийн орчинд хэрхэн амжилт олж болох талаар сургалт. Бизнесийн орчинд ямар шийдвэр амжилт авчрах нь тодорхойгүй байдаг ба гарч болох олон эрсдэлүүдийг хэрхэн хохирол багатайгаар даван туулж болох талаар заадаг. Grit буюу шүд зуун сорилтийг давах чадвар. Энэ дэд сэдэв дээр зарчимч тууштай байх байдал нь бизнес эрхлэгчийн амжилтанд хэрхэн нөлөөлөх талаар заадаг. Agility буюу хурдан шийдвэр гаргах чадвар. Мэдээж хэрэг өрсөлдөөн ихтэй бизнесийн орчинд хэн түрүүлж зөв шийдвэр эсвэл алхамыг хурдан хийж чадсан нь амжилт олдог. Боломжийн тоог нэмэгдүүлэх ур чадварыг эзэмших хичээлээр өөрт байгаа боломжуудыг тултал ашиглаж мөн өөрт байхгүй боломжийг хэрхэн нэмэгдүүлж болох талаар зааж өгдөг. Шийдвэр гаргах ур чадвар. Чухал шийдвэр гаргах хэцүү. Хурдан болон чанартай шийдвэр гаргах нь ямар ч бизнес эрхлэгчид байх чухал чадвар. Тохиролцоо хийх ятгах ур чадвар нь оролцогчдод түншлэлээс хэрхэн хоёр тал аль аль нь максимум ашигтай байж болох талаар заана. Үгнээс илүү үйлдэл дээр анхаарах чадвар нь бодитой мэдрэгдэхүйц үйлдэл хэрхэн хийх талаар заадаг. Одоогийн байдлаар Залуу Бизнес Эрхлэгчидийн Гүйцэтгэлийг Сайжруулж, Өсөлтийг Хурдасгах сургалтад Улаанбаатар хот болон Дорноговь, Дархан, Эрдэнэт, Баянхонгор аймгийн 80 орчим залуусыг хамруулж хэрэгцээт чадваруудаас заасан байна.




ДИЖИТАЛ СТРАТЕГИ

Энтерпренер залуучуудыг дэмжин ажиллахад дижиталчлал чухал үүрэг гүйцэтгэх болсон. YBI байгууллага нь гишүүн байгууллагуудын зорилтот бүлгүүддээ сургалт, мэдээлэл хүргэхээс эхлүүлээд менторинг, зөвлөх үйлчилгээ, санхүүжилт болон зах зээлтэй холбох зэрэг бүхий л үйлчилгээг цахимжуулах, дижиталчлахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Хөгжлийн Шийдэл ТББ нь YBI-тай хамтран байгууллагын дижитал стратегийг тодорхойлон, байгууллагын дотоод зохион байгуулалтыг цахим системд амжилттай холбож чадсан билээ. Ингэснээр Хөгжлийн Шийдэл ТББ-ын дотоод үйл ажиллагааны 80 хувь нь бүрэн цахимжаад байна. Томилот, сургалт уулзалт гэх мэт үйл ажиллагаа, ажилтаны өөрийн менежертээ өгдөг тайлан, цалингийн хүсэлт явуулахын өмнөх цагийн бүртгэл гэх мэт өмнө нь цаас, цаг хугацаа ихээр авдаг байсан үйлдэлүүдийг бүгдийг нь цахимжуулж чадсанаар байгууллагын хэмжээнд үр бүтээмж өндрөөр нэмэгдсэн. Мөн зорилтот бүлгийн үр шимийг хүртэгчдэд зориулан бизнесийг дэмжих үйлчилгээний чатбот хувилбарыг боловсруулах ажлыг гүйцэтгэж дууссан ба нэвтрүүлэхэд бэлэн болсон. Хөгжлийн Шийдэл ТББ болон YBM цахим хуудас, фейсбүүк хуудсуудад энэхүү чатбот байршин залуучуудад хувь хүний болон бизнесийн ур чадварыг хөгжүүлэх зохих мэдлэг, мэдээлэл, зөвлөмжийг текст, аудио болон дохионы хэлээр хүргэнэ. Харааны болон сонсголын тусгай хэрэгцээт бүлгийнхэн бизнес эрхлэгчдэд хэрэгцээтэй мэдээллүүдийг хялбархан авч чадах боломжтой болж байгаагаараа онцлог юм. Хувь хүний ур чадварын мэдээллүүд нь харилцаа, мэдлэг, сэтгэлгээ гэх гол сэдвүүд дээр анхаардаг бол бизнесийн ур чадварын хэсгээс санхүүжилт, маркетинг, бизнес загвар мөн үүнээс гадна төрөл бүрийн чухал хэрэгцээт мэдээллийг авах боломжтой.

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД



Хүнс, Хөдөө Аж
Ахуй Хөнгөн
Үйлдвэрийн Яам



Жижиг дунд
үйлдвэрийн газар



НЗДТГ



Хөдөлмөр Халамж
Үйлчилгээний Ерөнхий
Газар



Зээлийн батлан
даалтын сан



Америкийн Бэгдсэн
Улсын Олон Улсын
Хөгжлийн Агентлаг



НҮБ-ын Хүн
Амын сан



Оюу Толгой



Залуу Бизнесийг
Дэмжих Санаачлага
Youth Business Mongolia



Солонгосын олон улсын
хамтын ажиллагааны
байгууллага



Азийн сан



МҮХАҮТ



Монголын Бизнес
Зөвлөл



Хуульчдын
холбоо



Монголын
Менежментийн
Зөвлөхүүдийн
Институт



Банк Санхүүгийн
Академи



Америкийн Худалдааны
Танхим



Америкийн
Менежментийн
Холбоо



Герман Монголын
Бизнес Эрхлэгчдийн
Холбоо



Худалдаа
хөгжлийн банк



Голомт банк



Хаан банк



Хас банк



Төрийн банк



Кредит банк



Капитрон банк



Транс банк



Ард кредит ББСБ



Транскапитал
ББСБ



Жи Эс Би капитал
ББСБ



Инвекор ББСБ



Нийслэлийн
ЖДҮҮДТ



Богд банк



Комплиансын
Үндэсний Зөвлөл



ТОС



Нийслэлийн
Инновацийн Газар



Гүүд Нэйборс
Монгол



ЭсДиСи Хөдөлмөр
Эрхлэлтийг Дэмжих
төсөл, ЖиЭФЭИ зөвлөх
групп



Дэлхийн банкны
Хөдөлмөр Эрхлэлтийг
Дэмжих Төсөл



ПиЭмАй



МБИҮНХ



Австралийн
Худалдааны
Танхим



Швейцарын
хөгжлийн агентлаг